

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар  
сарын 25-ны өдрийн А/261 дүгээр  
тушаалын нэгдүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР  
БАРАА ХУДАЛДАН АВАХ  
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН  
ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

2024 он

ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР  
БАРАА ХУДАЛДАН АВАХ  
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН  
БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

Цэвэр усны ухаалаг тоолуур худалдан авах (Ус суваг  
ХХК)

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

ХӨАХААГ/20240202051

БАТЛАВ:

АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

## САНАМЖ

Тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер нь захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний гол нөхцөл болох тул тендер шалгаруулалт зохион байгуулах, түүнд оролцохын өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүнийг даган батлагдсан журам, заавар, дүрэм, гэрээний нөхцөл, тендер шалгаруулалтын жишиг баримт бичигтэй сайтар танилцахыг зөвлөж байна.

Захиалагч нь тендер шалгаруулалт зохион байгуулахад худалдан авах ажиллагааны үндсэн зарчмууд болох өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, хариуцлагатай, үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг баримтална.

Энэхүү харьцуулалтын аргын тендер шалгаруулалтын баримт бичиг нь тендер шалгаруулалтын зааварчилгаа, өгөгдлийн хүснэгт, техникийн тодорхойлолтын шаардлага, тендерийн жишиг маягт, гэрээний нөхцөл гэсэн бүлэгтэй.

Тендер шалгаруулалтын зааварчилгаа (цаашид “ТШЗ” гэх) бүлгийн зүйл, заалтыг нэмж, эсхүл өөрчилж үл болох бөгөөд захиалагч, оролцогч-сонирхогч этгээд нь тэдгээрийг баримтална. Захиалагч тендерийн баримт бичгийг боловсруулахдаа ТШЗ-нд үндэслэн, худалдан авах барааны онцлогийг харгалзан өгөгдлийн хүснэгт (ӨХ)-ийг боловсруулах ба шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтэд нийцүүлэн бэлтгэнэ.

Техникийн тодорхойлолт бүлэгт захиалагчийн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой хэрэгцээ, шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгасан байна.

Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд үндэслэн жишиг маягтуудын хаалт дотор напуугаар бичсэн тохирох мэдээллийг зааварт нийцүүлэн бүрэн, үнэн зөв бөглөж ирүүлнэ. Гэрээний нөхцөл бүлэг нь захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулагдах гэрээний зүйл, заалтууд тул талууд үүнийг судалсан байвал зохино.

Харьцуулалтын аргын тендер шалгаруулалтын анхаарах асуудлууд:

- ❖ Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээ /Бараа цахим каталогт бүртгэгдсэн байна./
- ❖ Тендер шалгаруулалтын зарлал нийтэлж, бүртгэлтэй аж ахуй эрхлэгчид урилга хүргүүлж, үнийн санал дуудна. Тендер шалгаруулалтын баримт бичгийг цахим систем [/www.tender.gov.mn/-д нийтэлнэ.](http://www.tender.gov.mn/)
- ❖ Үнийн саналыг дуудах хугацаа нь урилга хүргүүлсэн, зарлал нийтэлсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй өдрийн дараа байхаар тогтоосон байна.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдэд цахим системээс ялгах дугаар олгоно.
- ❖ Заасан хугацаанд сонирхогч этгээд тендерийг цахим системд ирүүлнэ.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагааг 2 хүртэл цагийн хугацаагаар зохион байгуулна. Уг хугацааны дотор саналыг бууруулан хэдэн ч удаа ирүүлж болно.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад өсөх дарааллаар **ЭХЭНД ЭРЭМБЭЛЭГДСЭН** үнийн санал бүхий оролцогчийг тодорхойлно.
- ❖ Эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн **тендерийг хянан үзэж, шаардлага хангасан бол гэрээ байгуулах эрх олгоно.**

Эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол удаах **ЭРЭМБЭЛЭГДСЭН** тендерийг хянан үзнэ.

## **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА**

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА .....	5
II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ .....	12
III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА .....	15
IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ .....	22
V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ .....	25

## I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

<b>A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>	
<b>1. Тендерийн цар хүрээ</b>	1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгт (цаашид “ӨХ” гэх)-д заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтын баримт бичгийг гаргаж байна. Зарлалын дугаар, тендер шалгаруулалтын нэр, дугаар, багцын мэдээлэл өгөгдлийн хүснэгтэд бичигдэнэ.
<b>2. Санхүүжилтийн эх үүсвэр</b>	2.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр, төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
<b>3. Худалдан авах ажиллагааны тогтоомж хууль</b>	<p>3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.</p> <p>3.2. Худалдан авах ажиллагаанд захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.</p>
	3.3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20 <sup>1</sup> , 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй.
<b>4. Оролцогч, сонирхогч этгээдэд тавигдах ерөнхий шаардлага</b>	<p>4.1. Оролцогч хуулийн 7.1.1-7.1.9-д заасан нөхцөлийг хангасан байна.</p> <p>4.2. Түншлэлээр оролцох тохиолдолд түншлэлийн гишүүн бүр ерөнхий шаардлага хангасан байна.</p> <p>4.3.. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.</p> <p>4.4. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.</p> <p>4.5. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.</p>
<b>5. Туслан гүйцэтгэгч</b>	<p>5.1. Хуулийн 6.4-т зааснаар тендерийн үнийн 20 хүртэл хувьтай тэнцэх гүйцэтгэлийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэх тохиолдолд туслан гүйцэтгэх үүргийг гэрээнд заасан байна.</p> <p>5.2. Туслан гүйцэтгүүлэх хувь хэмжээ тендерийн үнийн 20 хувиас хэтэрсэн, эсхүл туслан гүйцэтгүүлэх тоо хэмжээг заагаагүй бол туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.</p> <p>5.3. Туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.</p>

<b>6.Бараанд тавигдах ерөнхий шаардлага</b>		<p>6.1.Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан бараа худалдан авахаас, эсхүл хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд оролцогч аль ч улсын гарал үүсэлтэй бараа санал болгож болно.</p> <p>6.2.Харьцуулалтын аргаар худалдан авах бараа Сангийн сайдын баталсан “Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам”-ын дагуу хуулийн 4.1.25-д заасан цахим катологид бүртгэгдсэн байна.</p>
<b>7.Худалдан ажиллагааны систем</b>	<b>авах цахим</b>	<p>7.1.Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.</p>
<b>Б.АГУУЛГА</b>		
<b>8.Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл</b>		<p>8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг дараах бүлэг болон түүний нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;</li> <li>II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;</li> <li>III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага, бараа нийлүүлэлтийн хуваарь;</li> <li>IV Бүлэг. Тендерийн жишиг маягт;</li> <li>V Бүлэг. Гэрээний нөхцөл.</li> </ul> <p>8.2.Тендер шалгаруулалтын зарлал, цахим системээр хүргүүлсэн урилга нь тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл болохгүй.</p> <p>8.3.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.</p>
<b>9.Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах</b>		<p>9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.</p> <p>9.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.</p> <p>9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.</p> <p>9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн тооцно.</p> <p>9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 10-д заасныг мөрдөнө.</p>
<b>10.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах</b>		<p>10.1.Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.</p> <p>10.2.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.</p> <p>10.3.Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт,</p>

	өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.
<b>11.Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт</b>	<p>11.1.Захиалагч сонирхогч этгээдийн тендер бэлтгэхтэй холбоотой асуултад хариулт өгөх уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>11.2.Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцно.</p> <p>11.3.Уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.</p>
<b>В.ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>12.Тендер шалгаруулалтын хэл</b>	<p>12.1.Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.</p> <p>12.2.Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.</p> <p>12.3.Хэрэв ТШЗ-ны 12.2-т заасан тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.</p> <p>12.4.Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.</p>
<b>13.Тендерийн бүрдэл</b>	<p>13.1.Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:</p> <p>13.1.1.ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;</p> <p>13.1.2.Тендерийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;</p> <p>13.1.3.ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;</p> <p>13.1.4.ТШЗ-ны 16-т заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;</p> <p>13.1.5.Бараа нийлүүлэлтийн хуваарь;</p> <p>13.1.6.Санал болгож буй бараа ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;</p> <p>13.1.7.ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;</p> <p>13.1.8.ТШЗ-ны 22.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;</p> <p>13.2.Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.</p>

<b>14.Тендерийн жишиг маягт</b>	14.1.IV бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.
<b>15.Хувилбарт санал</b>	15.1. Хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг ирүүлэх шаардлагатай бол өгөгдлийн хүснэгтэд заана.
<b>16.Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг</b>	16.1.ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1. 16.2.Хэрэв өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 7.1-д заасан ерөнхий нөхцөлийг магадлахтай холбоотой баримт бичиг. 16.3.Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ. 16.4.
<b>17.Чадавхын болон туршлагын шаардлага тавих үндэслэл</b>	17.1.ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тавихад хуулийн 15 дугаар зүйлийг баримтална. 17.2.Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй. 17.3.Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.. 17.4.Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
<b>18.Санхүүгийн чадавхын шаардлага</b>	18.1.Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна. 18.2.Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. 18.3.Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалzan үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй. 18.4.Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойши хөдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
<b>19.Техникийн чадавх болон туршлагын шаардлага</b>	19.1.Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна. 19.2.Техникийн болон туршлагын чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 17.2-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. 19.3.Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.

<b>20.Санал болгож буй бараанд тавигдах шаардлага</b>	<p>20.1.ТШЗ-ны 6.1-д заасан тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.</p> <p>20.2.Санал болгож буй барааны техникийн тодорхойлолтод нийцсэн болохыг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.</p> <p>20.3.Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно.</p> <p>20.4.Хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй боловч шаардлага хангах бол тунийг нотлох шаардлагатай.</p>
<b>21.Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээ</b>	<p>21.1.Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээтэй холбоотой өгөгдлийн хүснэгтэд заасан бол дараах баримт бичиг, мэдээллийг ирүүлнэ. Үүнд:</p> <p>21.1.1.санал болгож буй барааг тасралтгүй, горимын дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан хугацаанд ашиглахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалт, авах боломжтой хаяг, тэдгээрийн үнийн мэдээлэл;</p> <p>21.1.2.засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл.</p> <p>21.1.3.гадаадын этгээдийн хувьд нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт.</p>
<b>22.Тендерийн үнэ</b>	<p>22.1.Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад санал болгосон үнэ оролцогчийн тендерийн үнэ байна.</p> <p>22.2.Тендерийн үнэ гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх эсэхийг өгөгдлийн хүснэгтэд заана. Өгөгдлийн хүснэгтэд тогтмол байхаар заасан тохиолдолд тохируулга хийх нөхцөлтэй тендер ирүүлсэн бол шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.</p> <p>22.3.Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарыг дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.</p> <p>22.4.Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.</p> <p>22.5.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.</p>
<b>23.Тендерийн валют</b>	23.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай

	хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлнэ.
<b>24.Тендер хүчинтэй байх хугацаа</b>	<p>24.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.</p> <p>24.2.Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 24.1-д заасан хугацааг сунгаж болно.</p> <p>24.3.Оролцогч хугацааг сунгасан бол хуулийн 28.9-д зааснаар бичгээр мэдэгдэнэ.</p>
<b>Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ</b>	
<b>25.Тендер баталгаажуулах, илгээх</b>	<p>25.1.Тендерийг хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулан илгээнэ.</p> <p>25.2.Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол IV бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.</p> <p>25.3.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг IV бүлгийн Маягт 5-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</p> <p>25.4.Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.3-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэлд хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.</p>
<b>26.Тендер хүлээн авах эцсийн хугацаа</b>	26.1.Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
<b>Д.ҮНИЙН САНАЛ ДУУДАХ АЖИЛЛАГАА</b>	
<b>27.Үнийн санал дуудах хугацаа</b>	28.
<b>29.Тендер нээх</b>	29.1.ТШЗ-ны <b>Error! Reference source not found.</b> -т ааснаар хугацаа хаагдахад цахим систем оролцогч нарын санал болгосон эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлэх ба захиалагч зөвхөн эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендерийг нээнэ.
<b>Е.ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ /ХЯНАН ҮЗЭХ</b>	
<b>30.Тендерийг шаардлагад нийцэх эсэхийг хянан үзэх</b>	<p>30.1.Нээсэн тендерийг хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн Сангийн сайдын баталсан зааврын дагуу хянан үзнэ.</p> <p>30.2.Тендерт ирүүлсэн аливаа баримт бичгийн үнэн зөв, хүчинтэй байдлыг шалгаж үзэх эрхтэй байна.</p> <p>30.3.Эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ.</p>

<b>31.Тендерийн талаар тодруулга авах</b>	31.1.Тендерийг хянан үзэх явцад тодруулга авах шаардлагатай гэж үзвэл хуулийн 25 дугаар зүйлийг баримтална.
<b>Ё.МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>	
<b>32.Мэдэгдэл хүргүүлэх</b>	32.1.Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
<b>33.Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах</b>	33.1.Захиалагч ТШЗ-ны 8.1-д заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ. 33.2.Шалгарсан оролцогч ТШЗ-ны 33.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчийн тогтоосон хугацааны дотор хүргүүлнэ. 33.3.Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.
<b>Ж.БУСАД</b>	
<b>34.Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлах</b>	34.1.Захиалагч ТШЗ-ны 30.3-т зааснаар хянан үзээд бүх тендерээс татгалзсан бол шаардлага хангасан тендер ирээгүй шалтгааныг судалж, тендер шалгаруулалтыг дахин зарлах эсэх мэдээллийг хуулийн 28.1.3-т заасан шийдвэрт заана. 34.2.Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлахад хуулийн 34.11-д заасныг баримтална.
<b>35.Тендер шалгаруулалтад гомдол гаргах</b>	35.1.Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.

## II БҮЛЭГ.ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

<b>ТШЗ-НЫ ХОЛБОГОДХ ЗААЛТ</b>	<b>А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
<b>ТШЗ 1.1</b>	Захиалагчийн нэр: <b>Хөвсгөл аймгийн Худалдан авах ажиллагааны газар</b>
<b>ТШЗ 1.1</b>	Зарлалын дугаар: <b>ХӨАХААГ/20240202051</b> Тендер шалгаруулалтын нэр: <b>Цэвэр усны ухаалаг тоолуур худалдан авах (Ус суваг ХХК)</b> Тендер шалгаруулалтын багцын тоо болон нэр: <b>байхгүй</b>
<b>ТШЗ 2.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр: <b>Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө</b> Нийт төсөвт өртөг: <b>90,000,000 (Ерэн сая) төгрөг</b>
<b>Б.АГУУЛГА</b>	
<b>ТШЗ 9.2</b>	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хариуцсан ажилтан: Б.Болд -Худалдан авах ажиллагааны газрын Дотоод хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн Хаяг: <b>Хөвсгөл. Мөрөн сумын 8 дугаар баг, Чингүүнжавын талбай, Хөвсгөл аймгийн удирдлагын ордон, 108 тоот өрөө</b> Утасны дугаар: <b>70383809</b> Цахим шуудан: <b>khuvsulg-tender@khs.gov.mn</b>
<b>ТШЗ 11.1</b>	Тендер ирүүлэх өмнө уулзалт зохион байгуулах эсэх: <b>“ҮГҮЙ”</b>
<b>В.ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>ТШЗ 12.2</b>	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл.
<b>ТШЗ 15.1</b>	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>“ЗӨВШӨӨРӨХГҮЙ”</b>
<b>ТШЗ 16.2</b>	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> <li>Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ. Энэхүү тодорхойлолтыг ирүүлээгүй тохиолдолд тендер нээсэн өдрийн байдлаар татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн талаарх мэдээллийг шалгана.</li> <li>Шүүхийн тусгай архивын лавлагааг цахим системээс авч, зааварчилгааны дагуу цахим системээр холбогдох талбараар ирүүлнэ.</li> <li>Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй талаархи хүчин төгөлдөр лавлагааг цахим системээс авч, зааварчилгааны дагуу цахим системээр холбогдох талбараар ирүүлнэ.</li> </ol>
<b>ТШЗ 18.1</b>	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: <b>“Шаардана”</b></p> <ol style="list-style-type: none"> <li>Борлуулалтын орлогын хэмжээ: 2022, 2023 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 40 хувь болон түүнээс багагүй байна.</li> <li>Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 40 хувиас багагүй байна.</li> <li>Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна.</li> </ol>
<b>ТШЗ 18.2</b>	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> <li>Сүүлийн 2 жил (2022, 2023 он)-ийн санхүүгийн тайлан. Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхийг Сангийн яамны санхүүгийн тайлангийн <a href="http://www.e-balance.mof.gov.mn">www.e-balance.mof.gov.mn</a> мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангаас</li> </ol>

	<p>шалгах тул санхүүгийн тайланг ирүүлэх шаардлагагүй. Тендерт оролцогчийн санхүүгийн тайлан нь Сангийн яамны санхүүгийн тайлангийн <a href="http://www.e-balance.mof.gov.mn">www.e-balance.mof.gov.mn</a> мэдээллийн системд ороогүй тохиолдолд тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>2. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тендерт оролцогчийн харилцагч банкны дансны үлдэгдэл;</li> <li>- Харилцагч банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт;</li> <li>- Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд.</li> </ul> <p>3. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан шалгах боломж бүхий QR кодтой “Зээлийн мэдээллийн лавлагаа”-г тендерт хавсарган ирүүлнэ. Зээлийн ангилал нь “Хэвийн”-ээс бусад ангилалтай тохиолдолд татгалзах үндэслэл болно. (“Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг <a href="http://www.sainscore.mn">www.sainscore.mn</a>, <a href="http://www.burenscore.mn">www.burenscore.mn</a> хаягаар хандан авна. Хугацаа хэтэрсэн зээл, өр төлбөртэй эсэх талаар харилцагч банкнаас ирүүлсэн тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалzan үзэхгүй)</p> <p>4. Сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл.</p> <p>5. Тендерт оролцогч нь Сангийн сайдын “Аж ахуйн нэгж байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг тогтоох журам батлах тухай” 2016 оны 41 дүгээр тушаалд заасны дагуу 500.0 сая төгрөг түүнээс дээш хэмжээний хөрөнгөтэй эсхүл 1.5 тэрбум төгрөг түүнээс дээш хэмжээний жилийн борлуулалтын орлоготой бол санхүүгийн тайланд аудитын дүгнэлт ирүүлнэ</p>
<b>ТШЗ 19.1</b>	<p>Техникийн чадавх болон туршлага: <b>“Шаардана”</b></p> <p>Ижил төстэй гэрээний туршлага:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: Шаардана. Сүүлийн 3 жил (2021, 2022, 2023 он) аль нэг жилд нь доод тал нь нэг удаа батлагдсан төсөөвт өртгийн 70 хувиас багагүй үнийн дүн бүхий шингэний эзэлхүүн хэмжигч тоолуур нийлүүлэх гэрээний үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байна.</li> <li>2. Ижил төстэй ажил гүйцэтгэж байсан туршлагын мэдээллийг <b>Тендерийн баримт бичгийн IV бүлгийн 2, 3 дугаар МАЯГТ-аар ирүүлнэ.</b></li> <li>3. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: <b>“Шаардана” Тендерийн баримт бичгийн IV бүлгийн 4 дүгээр МАЯГТ-аар ирүүлнэ.</b></li> </ol> <p>4. Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: <b>“Шаардана”</b></p> <p>4.1. Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын шаардлага: Гэрээний гүйцэтгэлийг хариуцах албан тушаалтны иргэний үнэмлэхний хуулбар, мэргэжлийн дипломын хуулбар, компаниас олгосон итгэмжлэл (Компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд бол итгэмжлэл шаардлагагүй), хаяг, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг, эрхэлж бөй албан тушаалын мэдээллийг тус тус ирүүлнэ.</p>

ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <p>1.1) Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагын шаардлагын хувьд дараах баримт бичгийг ирүүлнэ:</p> <p>1.1.1) Зөвхөн захиалагчийн тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-ийн 1 заасан төсөвт өртөгтэй тэнцэхүйц үнийн дүн бүхий “<b>Шингэний эзэлхүүн хэмжигч</b>” тоолуур нийлүүлэх гэрээ (Энэхүү гэрээ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх хэсэгт заасан захиалагч байгууллагад “шингэний эзэлхүүн хэмжигч тоолуур” нийлүүлсэн гэрээ байх боломжтой);</p> <p>1.1.2) Захиалагчийн тендерийн баримт бичгийн ТШЗ-ийн 19.2-ын 1.1.1-д заасан гэрээгээр нийлүүлсэн барааг захиалагч хүлээн авсан акт;</p> <p>1.2) Захиалагчийн тендерийн баримт бичгийн ТШЗ-ийн 19.2-ын 1.1.1-д заасан гэрээгээр нийлүүлсэн бараанд чанарын баталгааны хугацаанд үйлдвэрэлэл, тээвэрлэл, хадгалалтын горимууд болон тухайн барааны чанар, стандарт (хуурамч)-аас хамаарсан эвдрэл, гэмтэл гараагүй талаарх тодорхойлолтыг холбогдох захиалагчаас авч ирүүлнэ.</p> <p>2. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх дараах баримт бичиг ирүүлнэ. Үүнд:</p> <p>2.1. Тендерт оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан ажлын гүйцэтгэлийн явцын талаарх мэдээллийг тус тус ирүүлнэ.</p>
ТШЗ 19.3	<p>Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ шаардлагатай эсэх: “<b>Шаардана</b>”</p> <p><b>1. Тендерт оролцогч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.17.1, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн дагуу Хэмжил зүйн төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийг ирүүлнэ.</b></p> <p><b>2. Тендерт оролцогч нь ухаалаг тоолуурын программ хангамжийн асуудлыг шийдвэрлэх, туршилт, тохицуулга, зүгшруулэлт хийх, 1 жилийн хугацаанд программ хангамж, тоолуурын ашиглалтын байдалд үнэлэлт дүгнэлт заавар, зөвлөгөө өгч ажилчдыг сургах асуудлуудыг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх баталгааг бичгээр ирүүлнэ.</b></p>
ТШЗ 20	<p><b>Санал болгож буй бараанд тавигдах шаардлага:</b></p> <p>1. Үйлдвэрлэгч эсхүл үйлдвэрлэгчтэй гэрээ байгуулсан албан ёсны гэрээт борлуулагчаас тухайн барааг тухайн тендерт оролцогчоор дамжуулан Монгол Улсад борлуулах зөвшөөрөл (Гэрээ эсхүл гэрээт борлуулагч болохыг нотлох бусад баримт бичиг)-ийг баталгаат орчуулгын хамт ирүүлнэ.</p> <p>2. Тендерт оролцогч нь санал болгож буй бараа захиалагчийн техникийн тодорхойлолт, тендерийн баримт бичигт нийцсэн болохыг нотлох баримтыг баталгаат орчуулгын хамт ирүүлнэ.</p> <p>2.1. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно.</p> <p>2.2. Хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй боловч шаардлага хангах бол түүнийг нотлох шаардлагатай.</p> <p>3. Тендерт оролцогчийн санал болгосон цэвэр усны ухаалаг тоолуур нь Стандарт хэмжил зүйн газраас Монгол Улсад ашиглахыг зөвшөөрсэн загварын баталгааны “гэрчилгээ”, хэмжих хэрэгслийн улсын бүртгэлд бүртгэгдсэн болохыг нотлох баримт бичгийг ирүүлнэ..</p>

	4. Тендерт оролцогч нь тендерт шалгарсан тохиолдолд тоолуур нэг бүрт эрх бүхий байгууллагаас олгосон баталгаажуулалтын гэрчилгээг захиалагчид хүлээлгэн өгөх баталгааг бичгээр ирүүлнэ.
ТШЗ 21.1	<p>1. Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээний талаарх мэдээлэл ирүүлэх эсэх: “ҮГҮЙ”</p> <p>2. Санал болгож буй барааг тасралтгүй, горимын дагуу ашиглах хугацаа: <b>6 жил</b></p> <p>3. Тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгатай холбоотой зааварчилгаа, мэдээлэл ирүүлэх эсэх: “<b>ТИЙМ</b>”</p> <p>4. Нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээтэй холбоотой бусад шаардлага:</p> <p>А) Шингэн хэмжигч ухаалаг тоолуурыг ашиглах явцад (чанарын баталгааны хугацаанд) ашиглалтын горимоос зөрчсөнөөс бусад байдлаар үүссэн эвдрэл, гэмтлийг засварлах эсхүл шинээр солих баталгааг бичгээр ирүүлнэ.</p>
ТШЗ 22.2	Оролцгчийн санал болгосон тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “ <b>ТОХИРУУЛАХГҮЙ</b> ”
ТШЗ 22.3	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: “ <b>ТИЙМ</b> ” Хэрэв “ <b>Тийм</b> ” бол <i>Incoterms</i> -ийн хамгийн сүүлийн хувилбарын <i>Incoterms 2020, DDP, Хөвсгөл аймгийн Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн Нутгийн удирдлагын ордонд хүргэнэ.</i>
<b>Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ</b>	
ТШЗ 25.4	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Захиалагчийн тендерийн баримт бичгийн ТШЗ 25.3-т зааснаас <b>гадна</b> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (ТБОНӨХБАҮХАТ)-ийн 7 дугаар зүйлд заасан оролцгчийн ерөнхий шаардлагууд</li> <li>2. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээлэл</li> <li>3. Тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу илгээсэн мэдээлэл</li> <li>4. Тендер шалгаруулалтын баримт бичигт ил болгохоор заасан бусад баримт бичиг</li> <li>5. Тендерт ирүүлсэн төсвийн товчоо;</li> <li>6. Ажил гүйцэтгэх хуваарь.</li> </ol> <p>ТБОНӨХБАҮХАТХуулийн 22.5-д заасан үндэслэлээр ил болгохгүй баримт бичиг, мэдээлэл байгаа бол нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалтыг ТШЗ-ны IV бүлгийн “Маягт 5” -ын дагуу бөглөж ирүүлнэ. Нууцалсан хууль зүйн үдэслэлийг оновчтой тодорхойлсон байна.</p>
ТШЗ 26.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь</p> <p>Огноо: <b>2024 оны 6 дугаар сарын 18-ний өдөр</b>  Цаг: <b>11 цаг 00 минут</b></p>

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.

- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөөт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайллан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.


БАТЛАВ  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ   
М.ХУЯГБААТАР  
...2024.оны 02 дугаар сарын 22.


ЦЭВЭР УСНЫ УХААЛАГ ТООЛУУР ХУДАЛДАН АВАХ

2024.02.05

Мөрөн

№	Багаж хэрэгсэл	Техникийн үзүүлэлт	Нийлүүлэлт
1	Смарт тоолуур	<p>Техникийн өрөнхий шаардлага хангасан байх MNS 6358:2023</p> <p>IC карттай хавхлагатай урьдчилсан төлбөрт цэвэр болон хэрэглээний усны тоолуур</p> <p>Тоолуурын бутэц их бие гуулин материалтай, тоолох механизм өндөр нарийвчлалтай</p> <p>Ажлын температур /-40-аас +75 хэм хүртэл/</p> <p>Хамгаалалт: Соронзын хамгаалалттай</p> <p>Үндсэн тэжээл: Баттери ( хамгийн багадаа 6 жилийн баталгаат хугацаатай)</p> <p>Хаалт: Төв диспетчерээс программ хангамжаар дамжуулж автоматаар хаалтыг нээж, хаах боломжтой</p> <p>Усны эзэлхүүнийг хэмжих хамгийн бага хуваарийн хуваагдал нь 50 мл ажлын хамгийн их даралт нь 10 бар,</p> <p>Программ хангамж нь усны хэрэглээ болон зарцуулалт цэнэглэлийн мэдээллийн санг үүсгэж төв серверт мэдээлэл боловсруулах анализ хийх график болон бусад тайлан гаргах боломжийг олгосон байх ба мэдээллийн системийн аюулгүй байдлыг бурэн хангасан</p> <p>Өгөгдөл хадгалах: Өдөр, сар, жилээр</p> <p>Дэлгэц: 9 оронтой LCD дэлгэцийн хэмжээ, урсгалын хурд, цахилгаан дохиолол, урсгалын чиглэл, гаралт гэх мэт.</p> <p>Холбогдох тоолуурын тоо: PLS хязгааралт байхгүй</p> <p>Ашиглалтын зардал: Ашиглалтын явцад зардал гарахгүй</p> <p>Баталгаат хугацаа 2-6 жил</p>	2024 он

ТАНИЛЦСАН:  
АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА   
Б.ОЮНТУЯА

ХЯНАСАН:  
"ХӨВСГӨЛ УС СУВАГ" ХХК-ИЙН  
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР   
Д.СҮХЭЭ

БОЛОВСРУУЛСАН:

## Техникийн тодорхойлолт

Санал болгох бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна. Хуулийн 26.8-д зааснаар эсхул түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэсэн техникийн тодорхойлолтод өөр бараа санал болгосон оролцогч техникийн тодорхойлолтод заасантай дүйцэх болохыг ТШЗ 20.2-т заасан баримт бичгээр нотолсон бол техникийн тодорхойлолтыг хангасан гэж үзнэ.

### Барааны нэр: Цэвэр усны ухаалаг тоолуур /Смарт тоолуур/

<b>№</b>	<b>Захиалагчийн техникийн тодорхойлолт</b>  (Тухайн барааны үзүүлэлт тус бурийг дор жагсааж бичих ба хэрээз чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	<b>Санал болгож буй техникийн тодорхойлолт</b>  (Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	<b>Тайлбар</b> (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1	Техникийн ерөнхий шаардлага хангасан байх <b>MNS 6358:2023</b>		
2	IC карттай хавхлагатай урьдчилсан төлбөрт цэвэр болон хэрэглээний усны тоолуур		
3	Тоолуурын бүтэц их бие гуулин материалтай, <u>тоолох</u> механизмын өндөр нарийвчлалтай		
4	Ажлын температур <u>-40-аас +75</u> хэм хүртэл/		
5	Хамгаалалт: Соронзны хамгаалалттай		
6	Үндсэн тэжээл: Баттери (хамгийн багадаа 6 <u>жилийн</u> баталгаат хугацаатай)		
7	Хаалт: Төв диспетчерээс программ хангамжаар дамжуулж автоматаар хаалтыг нээж, хаах боломжтой		
8	Усны эзэлхүүнийг хэмжих хамгийн бага хуваарийн хуваагдал нь 50 мл ажлын хамгийн их дараалт нь 10 бар,		
9	Программ хангамж нь усны хэрэглээ болон зарцуулалт цэнэглэлийн мэдээллийн санг үүсгэж төв серверт		

	мэдээлэл боловсруулах анализ хийх график болон бусад тайлан гаргах боломжийг олгосон байх ба мэдээллийн системийн аюулгүй <u>байдлыг бурэн хангасан</u>		
10	Өгөгдөл хадгалах: Өдөр, сар, жилээр		
11	Дэлгэц: 9 оронтой LCD дэлгэцийн хэмжээ, урсгалын хурд, цахилгаан дохиолол, урсгалын чиглэл, гаралт гэх мэт,		
12	Холбогдох тоолуурын too: PLS хязгааралт байхгүй		
13	Ашиглалтын зардал: Ашиглалтын явцад зардал гарахгүй.		
14	Тоолуурын эд анги нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материалаар хийгдсэн эд ангитай байх.		
15	Тоолуур нь MNS ISO 4064-152016 стандартын шаардлагыг бурэн хангасан байна. Электрон хэрэгсэлтэй усны тоолуурын бүтэц хийц нь ISO 4064/OIML R 49 энэ хэсэг, мөн 5.1 ба хавсралт В-ийн зарим шаардлагыг хангасан байх.		
16	Цэвэр усны ухаалаг тоолуур бүрт 1 жилийн хугацаанд чанарын баталгаа гаргана.		

[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан техникийн тодорхойлолтыг боловсруулна.]

## **Зураг, төсөл**

*Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.*

## БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө ]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа		
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)	7
1	2	3	4	5	6		
1	Цэвэр усны ухаалаг тоолуур	302	ширхэг	Хөөсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар	2024 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс гэрээг эхлүүлж, 2024 оны 8 дугаар сарын 06-ний өдрөөс өмнө барааг захиалагчид хүлээлгэн өгсөн байна.	[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]	

#### **IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ**

Захиалагч энэ бүлэгт оролцогчийн бөглөх шаардлагатай бүх маягтыг тусгана.

**Маягтын жагсаалт:**

<b>Маягт 1: Тендер илгээх маягт .....</b>	<b>23</b>
<b>Маягт 2: Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл.....</b>	<b>24</b>
<b>Маягт 3: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл .....</b>	<b>24</b>
<b>Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл .....</b>	<b>24</b>
<b>Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт .....</b>	<b>24</b>

## Маягт 1: Тендер илгээх маягт

[огноо]

### [Захиалагч байгууллагын нэр]

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтын үнийн санал дуудах ажиллагаанд эцсийн санал болгосон үнээр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.1. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
  - 3.1. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
  - 4.1. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна<sup>1</sup>
5. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
6. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын догодолгүй болохыг баталж байна.
7. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

**Баталгаажуулсан: Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:**

**Хаяг мэдээлэл:**

**Маягт 2: Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

**Маягт 3: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

Оролцгчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил □Үндсэн нийлүүлэгч □Түншлэлийн гишүүн □Туслан гүйцэтгэгч

**Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

**Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

## V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

### Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь захиалагч, гүйцэтгэгч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно.

Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох бараа худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол ГТН-ийн холбогдох заалтад тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан өөрчлөлт оруулан ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залпуулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөхгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, too хэмжээ зэрэгт нийцүүлэн тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>НЭГ.ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР</b>	
<b>Тодорхойлолт</b>	<p>1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:</p> <p>1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;</p> <p>1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;</p> <p>1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;</p> <p>1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;</p> <p>1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;</p> <p>1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;</p> <p>1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.</p> <p>1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;</p> <p>1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;</p> <p>1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;</p> <p>1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;</p> <p>1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;</p> <p>1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;</p> <p>1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны</p>

	үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориотой өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.
<b>Гэрээний тайлбар</b>	<p>1.2.Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:</p> <p>1.2.1.Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.</p> <p>1.2.2.Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.</p> <p>1.2.3.Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлахад бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.</p> <p>1.2.4.Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.</p> <p>1.2.5.Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.</p>
<b>ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ</b>	
<b>Бараа нийлүүлэх</b>	<p>2.1.Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй</p> <p>2.2.Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна</p> <p>2.3.ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.</p> <p>2.4.Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.</p>
<b>Бараа нийлүүлэх газар</b>	2.5.Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
<b>Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах</b>	<p>2.6.Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.</p> <p>2.7.Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:</p> <p>2.7.1.Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;</p> <p>2.7.2.Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.</p> <p>2.8.Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.</p> <p>2.9.ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.</p>
<b>Барааг хүлээлгэн өгөх</b>	2.10.Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.

	2.11. Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.
<b>Барааны гарал үүслийн улс</b>	<p>2.12. Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.</p> <p>2.13. Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.</p>
<b>Баглаа боодол</b>	<p>2.14. Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хийнэ.</p> <p>2.15. Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа бооддолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.</p> <p>2.16. Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрднө.</p>
<b>Худалдааны нөхцөл</b>	<p>2.17. Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана.</p> <p>2.18. ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.</p>
<b>ГУРАВ. ЗАХИАЛАГЧ</b>	
<b>Барааг хүлээн авах</b>	3.1. Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
<b>Шалгалт, туршилт</b>	<p>3.2. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.</p>
	<p>3.3. Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.</p> <p>3.4. ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.</p> <p>3.5. Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.</p> <p>3.6. Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.</p>
<b>Гэрээний үнэ</b>	<p>3.7. Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>3.8. Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.</p>
<b>Төлбөр төлөх</b>	3.9. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.

	<p>3.10. Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.</p> <p>3.11. Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</p> <p>3.12. Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.</p> <p>3.13. ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.</p> <p>3.14. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.</p> <p>3.15. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.</p>
<b>ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА</b>	
<b>Захиалагчийн хүлээх эрсдэл</b>	<p>4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;</p> <p>4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.</p>
<b>Даатгал</b>	4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.
<b>Доголдол</b>	4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.
	4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.
	4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.
	4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.
	4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.
	4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.
	4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.
<b>Чанарын баталгаа</b>	4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.

### ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

	<p>4.11.ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.</p> <p>4.12.Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.</p> <p>4.13.ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p> <p>4.14.Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.</p> <p>4.15.ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.</p> <p>4.16.ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p>
<b>Алданги</b>	<p>4.17.Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.</p> <p>4.18.Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.</p>
<b>Оюуны өмчийн эрх зөрчих</b>	<p>4.19.Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.</p>
<b>Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал</b>	<p>4.20.Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>4.21.Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p>
	<p>4.22.Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p> <p>4.23.Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.</p>
<b>Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа</b>	<p>4.24.Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.</p> <p>4.25.Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.</p>
<b>ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ</b>	
<b>ГЕН 2.5.</b>	Бараа нийлүүлэх газар:

<b>Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл</b>	<p>5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:</p> <p>5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;</p> <p>5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;</p> <p>5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.</p> <p>5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.</p> <p>5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига, запилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.</p> <p>5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.</p> <p>5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.</p>
<b>Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл</b>	<p>5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.</p>

### **ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ**

<b>Төлөөлөгч</b>	<p>6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.</p> <p>6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.</p>
<b>Туслан гүйцэтгэгч</b>	<p>6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.</p>
<b>Нууцлал</b>	<p>6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусдад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.</p> <p>6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.</p>

<b>Мэдэгдэл</b>	<p>6.9.Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.</p> <p>6.10.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.11.Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.</p> <p>6.12.Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:</p> <ul style="list-style-type: none"> <li>6.12.1.баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;</li> <li>6.12.2.биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.</li> </ul> <p>6.13.Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.</p> <p>6.14.ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.</p>
<b>Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах</b>	<p>6.15.Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>6.15.1.ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;</li> <li>6.15.2.үнийн тохируулга хийсэн.</li> </ul>
	<p>6.16.Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.</p> <p>6.17.ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.</p>
<b>Маргаан шийдвэрлэх</b>	<p>6.18.Гэрээг биелүүлэхтэй холбогdon гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.</p>
	<p>6.19.Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.</p>
<b>Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар</b>	
<b>ГЕН 2.6.</b>	Бараа нийлүүлэх хугацаа: 2024 оны 8 дугаар сарын 06-ний өдрөөс өмнө
<b>ГЕН 2.10.</b>	<p>Бараа хүлээлгэн өгөх нөхцөл:</p> <p><b>Аймгийн Засаг даргын захирамжаар томилсон ажлын хэсэг барааг захиалагчийн техникийн тодорхойлолт, шалгарсан оролцогчийн тендерийн баримт бичигт санал болгосон шалгуур, өгөгдөл үндэслэн барааг хүлээн авна.</b></p> <p>Бараанд холбогдох баримт бичиг: <b>Захиалагчийн тендерийн баримт бичигт заасан баримт бичиг, гэрчилгээ, гаалийн бичиг, баталгаажуулалтын хуудас, тооног төхөөрөмжийн туршилтын акт,</b></p> <p>Угралт, суурилуулах Тендерт оролцогч нь ухаалаг тоолуурын программ хангамжийн асуудлыг шийдвэрлэх, туршилт, тохируулга, зүгшрүүлэлт хийх, 1 жилийн хугацаанд программ хангамж, тоолуурын ашиглалтын байдалд үнэлэлт дүгнэлт заавар, зөвлөгөө өгч ажилчдыг сургах асуудлуудыг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.</p>
<b>ГЕН 2.14.</b>	<p>Баглаа, боодол:</p> <p><b>Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх</b></p>

	<b>нөхцөлийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлсийг харгалзсан байна.</b>
<b>ГЕН 2.16</b>	Баглаа боодол түүний дотор гадна талд тэмдэглэгээ хийх: <b>Барааны сав баглаанд хаграх, гэмтэх аюултай гэсэн тэмдэг тэмдэглэгээг тавих, Хөөсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар гэх хаяг тавьсан байна.</b>
<b>ГЕН 2.17.</b>	Худалдааны нөхцөл: <i>Incoterms-ийн хамгийн сүүлийн хувилбарын Incoterms 2020, DDP, Хөөсгөл аймгийн Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн Нутгийн удирдлагын ордонд хүргэнэ.</i>
<b>ГЕН 3.8.</b>	Үнийн тохицуулга хийх аргачлал: Ашиглахгүй.
<b>ГЕН 3.9.</b>	Төлбөр төлөх хугацаа: Барааг захиалагч хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн акт, гүйцэтгэл гаргасан баримт бичиг, болон бусад шаардлагатай баримт бичгийг нийлүүлэгч захиалагчид хүлээлгэн өгснөөс хойш 21 хоногийн дотор санхүүжилтийг олгоно.
<b>ГЕН 4.2.</b>	Даатгал: <b>[Даатгалын нөхцөлийг тухайн бараа нийлүүлэлтийн онцлог болон худалдааны нөхцөлүүдийг харгалзан тодорхойлно. Даатгалын төрөл заах]</b>
<b>ГЕН 4.10.</b>	Баталгаат хугацаа: <b>1 жил</b>
<b>ГЕН 4.11</b>	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: “ <b>шаардана</b> ” <b>Чанарын баталгаа шаардах бол,</b> Чанарын баталгааны дүн: <b>Гэрээний үнийн дүнгийн 5 хувь байх</b>
<b>ГЕН 4.17.</b>	Нийлүүлэгчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: “ <b>Тийм</b> ” Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлэгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх алдангийг Захиалагчид төлнө. Захиалагч нь алдангийн хэмжээгээр нийлүүлэгчид төлөх гэрээний төлбөрийг бууруулна.
<b>ГЕН 4.18.</b>	Захиалагчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: “ <b>Тийм</b> ” Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлнө. Захиалагч нь нийлүүлэгчид төлөх гэрээний төлбөрийг алдангийн хэмжээгээр нэмэгдүүлж төлнө.

**ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР АЖИЛ  
ХУДАЛДАН АВАХ ҮЕД ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ**

(Гэрээний маягт нь нийтлэг бараа худалдан авахад зориулагдсан бөгөөд барааны онцлогт тохирсон гэрээний нөхцлийг гэрээний маягт, тусгай нөхцөлд тусгах үүргийг захиалагч болон үнэлгээний хороо хариуцна)

**БАТЛАВ:**

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
П.ЛХАГВАЖАВ

**ЗӨВШӨӨРСӨН:**

ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
/ /

**[Тендер шалгаруулалтын нэрийг бичих]** гэрээ.  
Дугаар № **[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]**

..... хот/аймаг

Нэг талаас Хөвсгөл аймгийн Засаг дарга П.Лхагважав (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[НИЙЛҮҮЛЭГЧИЙН НЭРИЙГ БИЧИХ]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг 202.. оны .... сарын ...-ны дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байх бөгөөд санхүүжилтийг гэрээний б дугаар хавсралтад заасан санхүүжилтийн хуваарийн дагуу олгоно.

1.1. Санхүүжилтийн эх үүсвэр:

1.2. Санхүүжилтийн нийт дүн:

Үүнээс: 202.. онд санхүүжих дүн:

2. Энэхүү гэрээгээр нийлүүлэх барааг 202... оны ... дугаар сарын ... –ны дотор захиалагч талд хүлээлгэн өгнө..

3. Гэрээний үнийг Нийлүүлэгч **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.

4. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

4.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

4.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;

4.3. Гэрээний 1 дүгээр хавсралт (Гэрээний тусгай нөхцөл);

4.4. Гэрээний 2 дугаар хавсралт (Гэрээний тусгай нөхцөл);

4.5. Гэрээний 4 дүгээр хавсралт (Барааны техникийн тодорхойлолт;

4.6. Гэрээний 5 дугаар хавсралт (Бараа нийлүүлэлтийн хуваарь);

4.7. Гэрээний 6 дугаар хавсралт (Санхүүжилтийн хуваарь);

4.8. Гэрээний 7 дугаар хавсралт (..... банкнаас гаргасан ..... дугаартай .... төгрөгийн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгаа);

4.9. Гэрээний 8 дугаар хавсралт (Бусад шаардлагатай баримт бичиг<sup>2</sup>);

4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:

<sup>2</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд

#### **4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл**

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

#### **4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл**

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

5. Гэрээ нь энд дурдсан барааг нийлүүлэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Тендер шалгаруулалтын явцад ашиг сонирхлын зөрчил үүсээгүй ч хожим гэрээ байгуулахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болбол талууд гэрээ байгуулахаас татгалзах үүрэгтэй.

7. Барааны нийлүүлэлт нь нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөхгүй.

8. Гэрээг хэрэгжүүлэх явцад гэрээний үнэ, тендерт заасан барааны техникийн тодорхойлолт болон түүний тоо хэмжээг зэрэг гэрээний агуулгатай холбоотой гэрээний нөхцөл өөрчлөхийг хориглоно.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харилцана.

10. Захиалгч урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэрээний 8 дэх хэсэгт зааснаас бусад асуудлаар зохих өөрчлөлт оруулж, тус өөрчлөлтийг бичгээр гаргаж талууд баталгаажуулсан нөхцөлд өөрчлөлтийг хүчин төгөлдөр болсонд тооцно.

### **11. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ**

11.1. Захиалагч нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйл, Иргэний хуулийн 249, 254 дүгээр зүйл болон холбогдох хууль тогтоомж, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл түүний хавсралтад заасан эрх, үүргийг заавал хэрэгжүүлж, гэрээтэй холбогдон үүсэх хариуцлагыг хүлээнэ.

11.2. Захиалагч талыг төлөөлж гэрээний хэрэгжилтийг удирдах захиалагчийн төлөөлөгчийг гэрээ байгуулснаас хойш 7 хоногийн дотор томилон ажиллуулна.

11.3. Захиалагч нь гэрээний хэрэгжилт, бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан үйл ажиллагаа, хугацаа, барааны чанарт байнгын хяналт тавих, сануулах, шаардах, дэмжлэг үзүүлэх зохицуулалт хийнэ.

11.4. Нийлүүлэгч талд холбогдох хууль журмыг сахин ханганд ажиллахыг анхааруулан хариуцсан мэргэжилтнийг ажиллуулахыг албан бичгээр шаардана.

11.5. Талууд хамтран бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу барааг хүлээн авах, хуваарилах, гүйцэтгэлийг баталгаажуулж, захиалагч, гүйцэтгэгчээс шалтгаалсан асуудлыг шуурхай шийдвэрлэх, энэ тухай мэдээллийг [www.tender.khs.gov.mn](http://www.tender.khs.gov.mn) сайт болон холбогдох бусад мэдээллийн хэрэгсэлд тухай бүр нийтэлэх үүргийг хэрэгжүүлж, худалдан авах ажиллагаанд ил тод, шударга байх зарчмыг хангана.

11.6. Хэрэв Нийлүүлэгч техникийн тодорхойлолт, чанар, стандарт хангахгүй бараа, дагалдах үйлчилгээг хүлээлгэн өгөхөөр санал болгосон тохиолдолд нийлүүлэлтийг зогсоох, доголдлыг арилгах мэдэгдлийг нийлүүлэгч талд хүргүүлж, гологдлыг арилгуулах, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

11.7. Бараа нийлүүлэлтийн явцын талаарх санал, хүсэлт, гомдлыг Захиалагчийн томилсон захиалагчийн төлөөлөгч албан бичгээр нийлүүлэгчид мэдэгдэнэ.

11.8. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг хугацаанд нийлүүлэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай

тэнцэх хэмжээний мөнгийг сүүлийн санхүүжилтээс суутган тооцож гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн дансанд байршуулна. Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, цэвэрлэгээ үйлчилгээнд ашиглах материал, хувцас хэрэгсэл зэрэг бараа материел худалдан авахад чанарын баталгаа шаардахгүй.

11.9. Гэрээний төлбөрийг санхүүжилтийн хуваарийн дагуу нийлүүлэтийн хэмжээнд тохируулан үр дүнгээр нь санхүүжүүлж болох бөгөөд гэрээний төлбөрийн 30-аас доошгүй хувийн санхүүжилтийг бараа болон дагалдах үйлчилгээг хүлээн авч, гэрээ дүгнүүлсний дараа олгоно.

11.10. Нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ, түүний гэрээний хэрэгжилтийн явцын мэдээлэл болон гэрээг дүгнэж, барааг, дагалдах үйлчилгээг хүлээн авсан баримт бичиг, тайланг аймгийн Орон нутгийн өмчийн газарт тухай бүр ирүүлэх бөгөөд тус газар нь гэрээний хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, баримт бичгийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтад нийтлэх үүрэг хүлээнэ.

11.11. Нийлүүлэгчид олгох гэрээний төлбөрөөс дараах зардлуудыг захиалагчийн холбогдох дансанд суутгана. Үүнд:

- Барааг хүлээн авах, шалгалт, туршилт хийх, экспертийн дүгнэлт гаргуулах (шаардлагатай бол)-тай холбоотой аливаа зардлыг: ,,,,...,/ төгрөг
- Дагалдах үйлчилгээтэй холбогдох магадлашгүй ажил: ,,,,...,/ төгрөг

11.12. Захиалагч нь Нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх, гэрээний дагуу Нийлүүлэгчийн хүлээх үүрэг болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн бараа түүний дагалдах үйлчилгээг хүлээн авах, гэрээний төлбөрийн санхүүжилтийн хуваарийн дагуу төлөх болон чанарын баталгааны барьцаа хөрөнгө чөлөөлөх үүрэг хүлээнэ.

11.13. Хэрэв чанарын баталгааны хугацаанд барааны чанар, нийлүүлэлтийн өмнөх хадгалалт, тээвэрлэлтийн явцын гэмтэл согог, дагалдах үйлчилгээний чанаргүй гүйцэтгэлийн улмаас бараанд үссэн зөрчил, гологдлыг арилгах, хохиролыг нөхөн төлөх мэдэгдлийг Захиалагчаас Нийлүүлэгч талд бичгээр мэдэгдэх ба Нийлүүлэгч нь мэдэгдэл авсан өдрөөс хойш 20 хоногийн дотор зөрчил, гологдол, чанаргүй гүйцэтгэлийг арилгаагүй тохиолдолд Захиалагч чанарын баталгааны барьцаа хөрөнгөөр гологдлыг арилгах арга хэмжээ авах ба гологдлыг арилгахад барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд барьцаа хөрөнгөөс давсан зардлыг нийлүүлэгчээс нэхэмжилж авах эрх эдлэнэ.

11.14. Энэхүү гэрээний үүргийг “хангалттай” хэрэгжүүлсэн нийлүүлэгчийг “ногоон”, “хангалтгүй” хэрэгжүүлсэн Нийлүүлэгчийг “хар” хуудсанд тус тус бүртгэх ба захиалагч нь “хар” хуудсан бүртгэгдсэн этгээдийг “Тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл”-д бүртгүүлэхээр холбогдох байгууллагад хандах эрх эдэлнэ.

## 12. НИЙЛҮҮЛЭГЧИЙН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

12.1. Нийлүүлэгч тал нь Иргэний хуулийн 246, 249, 253, 256 дугаар зүйл болон холбогдох хууль тогтоомж, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл түүний хавсралтад заасан эрх, үүргийг заавал хэрэгжүүлж, гэрээтэй холбогdon үүсэх хариуцлагыг хүлээнэ.

12.2. Бараанд дагалдах үйлчилгээ үзүүлэх тохиолдолд тус үйлчилгээг нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон ажиллах хүч, машин тоног төхөөрөмжөөр гүйцэтгэх ба зайлшгүй шаардлагаар тендерт санал болгоогүй хүний нөөц, машин тоног төхөөрөмж ашиглах бол тэдгээрийг ажиллуулах зөвшөөрлийг захиалагчаас авна.

12.3. Захиалагчийн баталсан техникийн тодорхойлолтод заасан шалгуур, шаардлагад нийцсэн, чанар, стандартын шаардлага хангасан бараа, дагалдах үйлчилгээг нийлүүлэлтийн хуваарыт заасны дагуу захиалагчид хүлээлгэн өгөх, гэрээг дүгнүүлэх, Засгийн газрын 2023 оны ... дугаар тогтоолоор баталсан журмын дагуу гүйцэтгэлийн баримт бичиг үйлдэх, захиалагчаас шаардсан бусад баримт бичгийг Захиалагчид хүргүүлэх үүргийг тус тус Гүйцэтгэгч хүлээнэ.

12.4. Барааг шалгаж хүлээн авахад шаардлагатай гарал үүслийн гэрчилгээ, техникийн паспорт, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас, барааны каталоги, ашиглалт, засвар үйлчилгээний заавар, гаалийн бичиг, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан бусад баримт бичиг зэргээс тухайн бараа, дагалдах үйлчилгээнд хамаарах хэсгийг бараатай хамт захиалагчид хүлээлгэн өгнө.

12.5. Гэрээт ажилтай холбоотой төрийн байгууллага, захиалагчийн төлөөлөгчийн гаргасан хууль ёсны шаардлага, санал хүсэлт, гомдол, мэдэгдэл, акт, дүгнэлтийг тухай бүрхэрэгжүүлж биелэлт үр дүнг захиалагчийн төлөөлөгчид тайлагнана.

12.6. Энэхүү гэрээгээр талууд барааны техникийн тодорхойлолт, дагалдах үйлчилгээний тоо хэмжээ, нэр төрөл, бараа нийлүүлэх хугацааг харилцан тохиролцсон тул тоо хэмжээний зэрүү, гэрээний хүчинтэй хугацаанд болон хугацаа хэтэрснээс үүсэх аливаа эрсдэл, барааны үнийн өсөлт зэргийг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

12.7. Захиалагч болон олон нийтийн зүгээс барааны нийлүүлэлтийн явц, бараа, дагалдах үйлчилгээний чанарт хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх, тулгамдсан асуудлыг хамтран шуурхай шийдвэрлэхэд идэвхтэй оролцож, захиалагч эрх бүхий бусад байгууллаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, хариуг албан бичгээр тухай бүрхэрэгждэнэ.

12.8. Хэрэв бараа, дагалдах үйлчилгээний чанараас шалтгаалж бараанд гологдол, гэмтэл үүсвэл чанаргүй барааг шинэ бараагаар солих, чанаргүй бараанаас үүссэн хохиролыг нөхөн төлөх үүргүүдийг Нийлүүлэгч хүлээх бөгөөд захиалагчаас хүргүүлсэн мэдэгдэлд заасан хугацаанд зөрчил гологдлыг арилгаж барааг захиалагчид актаар хүлээлгэн өгнө.

12.9. Нийлүүлэгч нь энэ гэрээний 12.8-д заасан зөрчил, гологдол, эвдрэл, гэмтлийг захиалагчийн заасан хугацаанд засварлаагүй тохиолдолд тухайн зөрчил гологдлыг чанарын баталгааны барьцаа хөрөнгөөс гаргахыг захиалагч талд зөвшөөрнө. Хэрэв дээрх зөрчил, гологдолыг арилгахад чанарын баталгааны барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй болж захиалагчаас нэмэлт зардал гарвал хэтэрсэн зардлыг Нийлүүлэгч мөн хариуцна.

12.10. Нийлүүлэгч нь гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааг бараа хүлээн авч гэрээ дүгнэсэн тухай мэдэгдэл гарсанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байлгана. Гэрээний хугацаа дуусаагүй тохиолдолд урьдчилгаа төлбөрийн баталгааг чөлөөлөхийг хориглох бөгөөд баталгааг чөлөөлсөн нөхцөлд захиалагчийн шийдвэрээр гэрээг цуцлана.

12.11. Нийлүүлэгч нь бараа нийлүүлэлтийн үе шат бүрийн хэрэгжилтийн явц болон барааг хүлээлгэн өгсөн баримт бичиг, гэрээний хэрэгжилтийн мэдээлэл, бусад баримт бичиг, фото зургыг [www.tender.khs.gov.mn](http://www.tender.khs.gov.mn) сайтад тухай бүр нийтэлнэ.

### 13. ГЭРЭЭНИЙ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

13.1. Нийлүүлэгч нь тендерт өөрийн ирүүлсэн баримт бичиг, ажлын гүйцэтгэлийн талаар бүрдүүлж өгсөн зураг, төсөв, баримт материалын үнэн зөвийг бүрэн хариуцна.

13.2. Талууд бие биенийхээ өмнөөс гуравдагч этгээдийн өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

13.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэхгүй. Шилжүүлсэн тохиолдолд үүсэх үр дагаврыг шилжүүлсэн тал өөрөө хариуцна.

13.4. Гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй тал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Захиргааны ерөнхий хууль”, “Иргэний хууль бусад холбогдох хууль тогтоомж, гэрээ, гэрээний ерөнхий, тусгай нөхцөлд заасан хариуцлагыг хүлээнэ.

13.5. Гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд харилцан зөвшилцэж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцэж чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

### 14. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ ҮНДЭСЛЭЛ.

14.1. Дор дурьдсан нөхцөл байдал тогтоогдвол гэрээг цуцалж болно. Үүнд:

14.1.1. талууд энэ гэрээ болон гэрээний ерөнхий тусгай нөхцөлд заасан үүргээ хэрэгжүүлээгүй нь тогтоогдсон, гэрээний ерөнхий нөхцлийн ... дэх хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн.

14.1.2. Захиалагч, Нийлүүлэгч талууд гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас гэрээг сунгах бололцоогүй болсон эсхүл бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаа дуусгавар болсон,

14.1.3. захиалагчийн баталсан техникийн тодорхойлолтыг хангахгүй чанаргүй бараа нийлүүлсэн

14.1.4. Нийлүүлэгч гэрээний үүрэг, захиалагчийн болон эрх бүхий байгууллагын дүгнэлт, албан шаардлагыг биелүүлээгүй, гэрээний үүргээ зөрчсөн.

14.1.5. гэрээний талууд гэрээний үүргээсээ татгалзсан

14.2. Гэрээг цуцлах тохиолдолд гэрээ цуцалж байгаа тал нь нөгөө талдаа энэ тухай мэдэгдсэнээс хойш хуанлийн 14 хоногийн дараа гэрээг цуцлах шийдвэр гаргана.

14.3. Талуудын санаачлагаар гэрээг цуцалсан тохиолдолд гэрээг дүгнэж, хохиролыг тооцож, хохирол тооцсон мэдэгдлийг хариуцагч талд хүргүүлж, гэм буруутай тал хохиролыг барагдуулна.

## 15. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

15.1. Гэрээг 4 хувь үйлдэж захиалагч тал гурав, гүйцэтгэгч тал 2 хувийг хадгална. Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр болно.

15.2. Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 258 дугаар тушаалын хавсралтаар баталсан “ажил худалдан авах ажиллагаа”-ны тендерийн жишиг баримт бичгийн гэрээний ерөнхий нөхцөл, гүйцэтгэлийн баталгаа болон энэ гэрээний 4 дахь хэсэгт заасан баримт бичгүүд нь гэрээний салшгүй хэсэг байна.

15.3. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.

15.4. Энэхүү гэрээ нь гэрээ цуцалснаас бусад тохиолдолд зөрчил гологдлыг Гүйцэтгэгч тал харицан арилгаж дуусах өдөр хүртэл хүчинтэй байна.

## 16. ГЭРЭЭ ДҮГНЭХ

16.1. Захиалагч нь нийлүүлэгч байгууллагатай хамтран барааг хүлээн авах ажиллагааг зохион байгуулж, бараа нийлүүлэх гэрээг дараахь 2 үе шатаар дүгнэнэ: Үүнд:

16.1.1. хүлээн авах комисс ажиллаж гэрээ болон холбогдох хууль, журманд заасан баримт бичгийг хянаж, барааг хүлээн авсны дараа гэрээнд заасан санхүүжилтийг олгоно.

16.1.2. барааны баталгаат засвар (чанарын баталгааны хугацаа) дууссаны дараа гэрээг дүгнэж, чанарын баталгааг чөлөөлж, гүйцэтгэгчид олгоно.

16.1.3. Бараа нийлүүлэлтийн үндсэн гэрээ болон нэмэлт гэрээг бараа хүлээн авсан акт, гэрээний бусад нөхцлийг үндэслэн захиалагч, гүйцэтгэгч хамтран дүгнэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: ГҮЙЦЭТГЭГЧИЙГ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ТӨЛӨӨЛЖ:  
ГАЗРЫН ..... ХЭЛТСИЙН ДАРГА ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧ:

.....  
АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА

Огноо: **2024-06-18**  
Тендер шалгаруулалтын төрөл: Бараа  
Тендер шалгаруулалтын нэр: **Цэвэр усны ухаалаг тоолуур /Хөвсгөл Ус суваг ХХК/**  
Тендер шалгаруулалтын дугаар: : **ХӨАХААГ/20240202051**

Нийт төсөвт өртөг: **90,000,000 (Ерин сая) төгрөг**  
Тендер шалгаруулалтын арга: Харьцуулалт

1. **Хөвсгөл аймгийн Худалдан авах ажиллагааны газар** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: “**Үгүй**”
3. Үнийн санал дуудах ажиллагаанд шаардлагатай оролцогчийн тоо: **[Үнийн санал дуудах ажиллагаа хүчин төгөлдөр байхад шаардлагатай оролцогчийн тоог бичих]**
4. Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлэх журам: **[Журмыг бичнэ үү]**
5. Үнийн санал дуудах ажиллагааг **2024 оны 06 дугаар сарын 18-ний өдрийн 09 цаг минутад эхлүүлж** эхлүүлж, **2 цагийн** хугацаанд зохион байгуулна.
6. Тендерийг **2024 оны 06 дугаар сарын 18-ний өдрийн 11 цаг 00 минутаас** өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 06 дугаар сарын 18-ний өдрийн 11 цаг 10 минутад** нээнэ.
7. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: “**Зөвшөөрөхгүй**”
8. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх “**Эрхгүй**”
9. Тендер нь түүнийг нээнээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8 дугаар баг, Чингүүнжавын талбай, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын “A” байр 108 тоот өрөө

Утас: 70383809,

Цахим шуудангийн хаяг: **khuvsulgul-tender@khs.gov.mn**